САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

"Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-ийн 1 дүгээр хавсралт (Е)

**Маягт СЗХ04008**

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэдэгдэл огноо | Он | 2021 | Сар | 03 | Өдөр | 31 |
| 2 | Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр | БОДЬ ДААТГАЛ ХК | | | | | |
| 3 | Даатгалын бүтээгдэхүүний нэр | ЖОЛООЧИЙН ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ | | | | | |
| 4 | Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | | | | | |
| 5 | Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр | Шийдвэрийн нэр | | Огноо | | Дугаар | |
| | | Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай | | 2021.03.31 | | ТУЗ/2107 | |
| 6 | Цахимаар борлуулах эсэх | ✓ Тийм | | ☐ Үгүй | | | |
| 7 | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Овог | | Нэр | | | |
| | | Балсан | | Баярмагнай | | | |
| **Мэдээллийн төрлийг сонгоно уу.** | | | | | | | |
| 8 | Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах<br>✓ Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх | | | | | | |
| **Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл** | | | | | | | |
| 9 | Даатгалын зүйл | Жолоочийн эрүүл мэнд | | | | | |
| | Даатгалын үндсэн эрсдэл | Албан журмын даатгалын гэрээнд нэр нь бичигдсэн жолооч буюу даатгуулагч нь замын хөдөлгөөнд оролцож байх үедээ өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас өөрийн эрүүл мэндэд хохирол учруулах | | | | | |
| | Даатгалын нэмэлт эрсдэл | - | | | | | |
| | Даатгалын хураамжийн хувь, хэмжээ | 2.0% | | | | | |

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ**

1.1 Даатгуулагч даатгал хийлгэх болон нөхөн төлбөр авахтай холбогдсон худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
1.2 Согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслийг жолоодсон, гэмт хэргийн зорилгоор, хууль бусаар ашиглах үед үүссэн хохирол;
1.3 Гэрээний 4.1 –д заагдаагүй эрсдэлийн улмаас үүссэн хохирол;
1.4 Тээврийн хэрэгсэл эсвэл, тухайн ангиллын тээврийн хэрэслийг жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан, хязгаарлуулсан байх үед тээврийн хэрэгсэл жолоодсоноос учирсан хохирол;
1.5 Стандартын шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус, эсхүл тогтоосон журмын дагуу улсын бүртгэл, техникийн үзлэгт ороогүй, улсын дугааргүй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсоноос үүдсэн хохирол;
1.6 Компьютер томографикийн оношлогооны зардалд нөхөн төлбөр олгохгүй;
1.7 Даатгуулагчаас өөр этгээд тээврийн хэрэгслийг жолоодон явж байх үед бий болсон эрсдэл;
1.8 Даатгуулагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол.
   1.8.1 Даатгалын эрсдэлийн улмаас хохирол учирсан болохыг тогтоох боломжгүй;
   1.8.2 Гэрээний 7.4-д заасан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн бүрдүүлээгүй;